上海对外经贸大学
SHANGHAI UNIVERSITY OF INTERNATIONAL BUSINESS AND ECONOMICS

# Шанхайн худалдааны туршилтын чөлөөт бүсийн хөнгөвчилсөн арга хэмжээний инновац хөгжил


GAO YUNSHENG

**Профессор/ доктор**

**Шанхайн Гадаад эдийн засаг худалдааны их сургуулийн Олон улсын эдийн засаг худалдааны дээд сургууль**

# Contents


**Нэг.** Шанхайн худалдааны туршилтын чөлөөт бүсийн хөнгөвчилсөн шинэчлэл

**Хоёр.** Худалдааг хөнгөвчилөх хяналтын хэлбэрийг шинэлчлэлийн үр дүн

**Гурав.** Шанхайн худалдааны туршилтын чөлөөт бүсийн худалдааг хөнгөвчилсөн шинэчлэлийн цаашдын хөгжил






# “Чөлөөт худалдааны бүс” （FTZ）-ийн тухай ойголт

- Нэг болон түүнээс дээш гаалийн татвараас чөлөөлөх, мөн эдийн засгийн хувьд засгийн газрын оролцоо харьцангуй багатай бүсийг хэлнэ.



# “Чөлөөт худалдааны бүс” （FTZ）-ийн тухай ойголт

| | |
|---|---|
| **◆1973 он《Киотогийн конвенц》** | Зарим нутаг дэвсгэрт импортын гаалийн татварыг гаалийн хилээс гадна гэж үзэн ердийн гаалийн хяналтын системийг хэрэгжүүлэхээс чөлөөлөгдөнө. |
| **◆АНУ-ын гаалийн татварын зөвлөл** | Гаалийн татвараас чөлөөлөгдсөн бие даасан хаалттай бүс |
| **◆1984 оны НҮБ-ны Худалдаа, хөгжлийн бага хурлын тайлан** | Улсын гаалиар дамжуулах шаардлагагүй бүс Татвар тушаах эсвэл квотоор хязгаарлагдахгүй |

# “Чөлөөт худалдааны бүс” （FTZ）-ийн хэлбэр

——**Чөлөөт боомт хэлбэр： Гонконг,** Сингапур гэх мэт

——**Зуучлагчаар дамжуулан худалдаа хийх хэлбэр**：Панамын Кельн чөлөөт худалдааны бүс г.м

—— **Үйлдвэр худалдааны хэлбэр:**Хөгжиж буй орнуудад илүү тархсан

——**Экспорт, боловсруулалтын хэлбэр**：Филиппин, Тайвань зэрэг Ази-Номхон далайн бүс нутаг

——**Гаалийн баталгаат агуулахын хэлбэр:** Голланд Амстердам Харбор чөлөөт худалдааны бүс

——**Жижиглэнгийн худалдаа хэлбэр**: Арикын чөлөөт худалдааны бүс

——**Чөлөөт хилийн бүс**:Ихэвчилэн Мексикт ашигладаг

—— Санхүүгийн Чөлөөт бүс : Арабын Нэгдсэн Эмират улсын Абу Даби санхүүгийн чөлөөт бүс

# Дэлхийн гол худалдааны чөлөөт бүс

Introduce



## /Шанхай/-ын чөлөөт худалдааны туршилтын бүсийн ерөнхий мэдээлэл болон гарал үүсэл

●**2013оны 9-р сарын 18-ны өдөр，** Төрийн зөвлөл нь 《/Шанхайн чөлөөт худалдааны туршилтын бүсийн ерөнхий төсөл》-ийг баталсан.

●**2013оны 9-р сарын 29-ны өдөр，** /Шанхайн чөлөөт худалдааны туршилтын бүсийг албан ёсоор нээсэн.

●**2015оны 4-р сарын 21-ны өдөр**，Шанхайн чөлөөт худалдааны туршилтын бүсийг 7-н парк 120 км2 болгож өргөтгөсөн. Гуандун, Тяньжин, Фужянийн чөлөөт худалдааны туршилтын бүсийг нээсэн.

●Шанхай чөлөөт худадааны туршилтын бүс нь "Нээлттэй, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчилсөн, чөлөөт валют арилжаа, хяналт өндөр, хууль эрх зүйн орчинтой чөлөөт худалдааны бүс"-ийг байгуулсан.

# Нэг. Хятад （Шанхай） чөлөөт худалдааны бүсийн худалдааг хөнгөвчилсөн шинэчлэл

**1.Гаалийн бүрдүүлэлтийн шинэчлэл**
**2.Баталгаат гаалийн хяналтын шинэчлэл**
**3.Татвар хураах журмын шинэчлэл**
**4.Аж ахуйн нэгжийн удирдлагын шинэчлэл**
**5.Үйл ажиллагааны хөгжүүлэлт, шинэчлэл**

**5 бүлэг**
**23 зүйлийн шинэчлэл**

（Нэг） шинэчлэлийн ерөнхий удирдамж

***“Гурван өгүүлбэр ”*** *-ийг хэрэгжүүлэх*

***“ Тавжилсан ” зарчмын дагуу***

***“ 6-н талын гол ажил ”*** *-д түлхэц үзүүлэх*

# •“Гурван өгүүлбэр”

- 1. Төвлөрлийг сааруулж, эрчимтэй хөгжүүлэх
- 2.Гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчилөх
- 3.Аюулгүй, өндөр үр ашигтай ажиллах

# Нэгдүгээр төрөл: Гаалийн хилээр нэвтрүүлэлтийг хөнгөвчилөх шинэчлэлийн арга хэмжээ

## 【Төсөл1】Нэг шугамаар хилээр барааг оруулах “Эхлээд оруулах, дараа нь гаалийн бүрдүүлэлт хийх ”

Шинэчлэлийн агуулга

**шинэчлэлийн өмнө**

- барааг хилээр оруулахад аж ахуй нэгж нь эхлээд гаалиар оруулж бүртгүүлэх хүсэлт гаргаж, гааль нь хилээр нэвтрүүлэх бичиг баримтыг бүрдүүлж дууссаны дараа аж ахуйн нэгж хилээр нэвтрүүлэх баримтыг авч барааг бүс хүртэл тээвэрлэнэ.

**шинэчлэлийн дараа**

- барааг хилээр оруулахад , гааль нь мэдээллийн системийг түшиглэн аж ахуйн нэгжийг хилээр оруулах барааны мэдээ мэдээллийг ашиглан эхлээд барааг бүс рүү оруулахыг зөвшөөрдөг. Шанхайн гаалийн харьяа боомтын хяналтын талбайд үйл ажиллагаа явуулагч нь цахим мэдээ мэдээллийг ашиглан холбогдох барааны бичиг баримтыг бүрдүүлнэ. Барааг бүс хүртэл тээвэрлэсний дараа аж ахуйн нэгж нь тогтсон хугацаанд гаальд бүртгүүлэх хүсэлтийг гаргаж өгнө.


2-3 өдөр
Уламжлалт хэлбэр
Бараас боомт руу оруулах
Ажилтан
Гаалийн бүрдүүлэлт
ажилтан
Гаалийн Хяналт шалгалт
Бараас авах
Бүс рүү оруулах порт дээр шалгах
Хагас өдөр
Шинэ хэлбэр
Бараас боомт руу оруулах
Цахимжуулсан
Бараас авах өргөдөл
Системийн автомат хяналт
Бараас авах
Бүс рүү оруулах порт дээр шалгах
Гаалийн бүрдүүлэлт

# Гааль бүрдүүлэлтийн хөнговчилсөн шинэчлэл

## Төсөл2. Бүсийн өөрийн тээвэрлэлтийн систем

Бүсийн шаардлага хангасан аж ахуйн нэгж нь гаалийн хяналтын авто машиныг дахин ашиглахгүй.

4-н тусгай хяналтын бүс нь хоорондын мэдээлэл солилцох байдлаар өөрсдөө тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.






# 【Төсөл2】Бүсийн аж ахуйн нэгж нь барааг дамжуулан өөрөө тээвэрлэх

**шинэчлэлийн өмнө**

**Шинэчлэлийн агуулга**

**шинэчлэлийн дараа**

- Туршилтын бүсийн хамрах хүрээнд байгаа гаалийн тусгай хяналтын бүс хоорондын барааны урсгалд транзит тээврийн хэлбэрийг ашигладаг. Түүнчлэн гаалийн хяналттай авто машинаар барааг тээвэрлэнэ.

- Туршилтын бүсийн аж ахуйн нэгж нь гаальд бүртгэлтэй өөрийн эзэмшлийн авто машин эсвэл холбогдох тээврийн тусгай зөвшөөрөлтэй тээвэрлэлтийн аж ахуйн нэгжийн авто машинаар туршилтын бүсэд өөрсдөө барааг шилжүүлэн тээвэрлэж болно.

# Гааль нэвтрүүлэлтийн хөнгөвчилсөн шинэчлэл

## Төсөл3.Ухаалаг картны гаалийн бүрдүүлэлтийн систем

Хийж гүйцэтгэсэн



# 【Төсөл3】Ухаалаг картаар шалгалт хийх

**Шинэчлэлийн агуулга**

**шинэчлэлийн өмнө**

- Авто машин, барааг оруулах, гаргах ажилчид нь бичиг баримтыг бүрдүүлдэг,

**шинэчлэлийн дараа**

- Картны ажиллагааг хялбаржуулж, картны байгууламжийг шинэчилж, автоматаар таних, автомат шалгалтыг тус тус хийж гүйцэтгэж, авто машинаар нэвтрэх хугацааг богиносгож гаалийн хилээр нэвтрүүлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ./Сунжянь, Цаохежин экспорт, борлуулалтын бүсэд картыг өргөн ашиглах болсон./

# Гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчилсөн шинэчлэл

## Төсөл4.Багцаар нь оруулж гаргах, нэгдсэн байдлаар бүртгэх систем




Барааг багцаар нь оруулж , гаргах, байдлаар нэгдсэн гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг бүрдүүлэхийг зөвшөөрнө.

## 【Төсөл4】Багцаар нь оруулж, гаргах, байдлаар нэгдсэн бүрдүүлэлт хийх

**Шинэчлэлийн агуулга**

**шинэчлэлийн өмнө**

- Гаалийн мэдүүлэгт тасалбар бүрээр бүрдүүлэлт хийхийг гол болгож, нэгдсэн мэдүүлгийг туслахаа болгож, хоёрдугаар шугам дээр хэрэгжүүлдэг.

**шинэчлэлийн дараа**

“Олон тасалбараар нэг бүрдүүлэлт” болгож өөрчилж, аж ахуйн нэгжийг багцаар нь барааг оруулж, гаргаж, тогтсон хугацаанд нэгдсэн журмаар гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг бүрдүүлэхийг зөвшөөрдөг.

# Гааль бүрдүүлэлтийн хөнгөвчилсөн шинэчлэл

**Төсөл5.** ***Автоматаар шалгах, гол цэгийг дахин шалгах зарчим***

✓ Хийж гүйцэтгэсэн



Ажилтан тасалбар бүрээр шалгах

Автоматаар хянаж, нэвтрүүлэх, ажилтан нь гол цэгийг дахин шалгах

**Автомат хяналтыг гол болгож , цаасан баримтын шалгалтыг туслахаа болгосон гаалийн бүрдүүлэлтийн хэлбэр**

## 【Төсөл5】 *Автоматаар шалгах, гол цэгийг дахин шалгах*

**Шинэчлэлийн агуулга**

Гаалийн хяналтын үйл ажиллагааны горимыг шинэчилж, аж ахуйн нэгжийн бага эрсдэлтэй баримтанд автомат хяналт, шалгалтыг хэрэгжүүлнэ.

# Гааль бүрдүүлэлтийн хөнгөвчилсөн шинэчлэл

***Төсөл6.Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны дагалдах бичиг баримтыг хөнгөвчилсөн.***

✓ хийж гүйцэтгэсэн

Нэг шугамны хилээр оруулж, гаргах бүрдүүлэлтийн жагсаалт

Хоёрдугаар шугамны татвар хөндөөгүй импорт, экспортын мэдүүлгийн хуудас




Шаардлагатай үед аж ахуйн нэгжээс гаргаж өгөхийг дахин шаардана.

# Гааль бүрдүүлэлтийн хөнгөвчилсөн шинэчлэл

Төсөл7.Нэгдсэн бүртгэлийн жагсаалт

Хийж гүйцэтгэсэн

**Тусгай хяналтын бүсийн хоёр төрлийн бүртгэлийн жагсаалт**

36-н зүйлийн мэдүүлгийн элемент （Вай Гаочиао）

42 -н зүйлийн мэдүүлгийн элемент （Яаншань, онгоцны буудлын нэгдсэн бүс гэх мэт ）

**шинэчлэлийн дараа**

30 -н зүйлийн мэдүүлгийн элемент

# 【Төсөл7】Нэгдсэн бүртгэлийн жагсаалт

**Шинэчлэлийн агуулга**

**шинэчлэлийн өмнө**

**шинэчлэлийн дараа**

▪шинэчлэлийн өмнө:
Вайгаочиа гаалийн хяналтын бүс зүйл нь 36-н нэр төрөл.
Яаншань баталгаалт гаалийн боомтын бүс болон фүдун нисэх онгоцны талбайн нэгдсэн гаалийн баталгаат бүсийн бүртгэлийн жагсаалтын мэдүүлгийн зүйл нь 42 зүйлтэй.

▪шинэчлэлийн дараа:
Бүсийн бүртгэлийн жагсаалтын маягтыг нэгдсэн журмаар хялбаршуулж, мэдүүлгийн элементийг нэгдсэн журмаар 30-н зүйлтэй болгоно.

# Хоёрдугаар төрөл: Баталгаат гаалийн хяналтын шинэчлэл

## Төсөл8.Боловсруулалт, худалдааны баримт шалгах журам

Хийж гүйцэтгэсэн



# Баталгаат гаалийн хяналтын шинэчлэл

***Төсөл9.Баталгаат гаалийн ложистикийн сүлжээний хяналтын зарчим***

✓ Хийж гүйцэтгэсэн



Гаалийн бүрдүүлэлт Бүртгэлийн тоо баримт

Гаалийн үйл ажиллагааны систем

Агуулахын бодит цаг хугацааны хяналт

**Системийн холболт**

Аж ахуйн нэгжийн агуулахын удирдлагын систем

- Барааны нэрний HS мэдээлэл
- Тоо хэмжээний мэдээлэл
- Үнийн мэдээлэл
- Байршлын мэдээлэл
- Хадгалалтын мэдээлэл
- Ложистикийн мэдээлэл
- Бүртгэлийн мэдээлэл гэх мэт




Барааны цахим тэмдэглэгээ

# Баталгаат гаалийн хяналтын шинэчлэл

**Төсөл10.Бүртгэл "Нэг удаа бүртгүүлж, олон удаа ашиглах" зарчим**

Хийж гүйцэтгэсэн

**Чөлөөт худалдааны бүсийн мэдээ мэдээллийн удирдлагын систем**

- Гаалийн баталгаат боловсруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бүртгэл
- Гаалийн баталгаат ложистикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бүртгэл
- Гаалийн баталгаат үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бүртгэл
    - Оношлогоо засварын глэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бүртгэл
    - Судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бүртгэл
    - Гаалийн баталгаат үзэсгэлэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бүртгэл
    - Фьючерс баталгаат хүргэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бүртгэл
- Гаалийн баталгаат бүсийн өргөтгөлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бүртгэл

**Бүртгэл "Нэг удаа бүртгүүлж, олон удаа ашиглах" зарчим**

## 【Төсөл10】 *“Нэг удаа бүртгүүлж, олон удаа ашиглах ” зарчим*

**Шинэчл элийн агуулга**

Бүсийн аж ахуйн нэгж нь нэг удаа бүртгүүлсэний дараа дахин гаальд бүртгүүлэх шаардлагүй, “ Багцаар нь оруулж, гаргах, нэгдсэн журмаар мэдүүлэх ” , “ Баталгаат гаалийн үзэсгэлэн худалдаа” , “Дотоод, гадаад засвар” 、 “Фьючерс баталгаат хүргэлт ” , “ Санхүүгийн түрээс зэрэг гаальд шалгуулах шаардлагатай үйл ажиллагааг явуулж болно.

# Гуравдугаар төрөл: Татвар тушаах журам шинэчлэл

**Төсөл11.*Нэгдсэн журмаар татвар тушаах зарчим***

Хийж гүйцэтгэсэн



Нэг тасалбараар нэг татвар тушаах

Нэгдсэн журмаар татвар тушаах

Аж ахуйн нэгж нь тогтсон хугацаанд болон хүчин төгөлдөр баталгаатай нөхцөлд нэвтрүүлсэн бараанд гаальд нэгдсэн журмаар татварыг тушаана.

# 【Төсөл11】Нэгдсэн журмаар татвар тушаах

**шинэчлэлийн өмнө**

**Шинэчлэлийн агуулга**

**шинэчлэлийн дараа**

- Гаалийн татвар хураамж нь уламжлалт тасалбар бүрээр татвар авч нэвтрүүлэх хэлбэртэй.

Татвар хураамжийн “Урагш шилжүүлэх”, “Хойш нь шилжүүлэх” зарчмыг улам боловсронгуй болгосон.

# Таварын хураамжийг шинэчлэх журам

***Төсөл12.Бүсийн сонгох боломжтой татвар хураамжийн журам***

*Хийж гүйцэтгэсэн*




Орох  материал болон эд анги



Бодитоор бэлэн бүтээгдэхүүнийг шалгана.

**аж ахуйн нэгж нь нэгийг нь сонгон авч импортын татварыг тушаана.**

# Татвар хураамжийг шинэчлэх журам

**Төсөл13.Бие даан татвар мэдүүлэх, гаалийн гол цэгийн хяналтын зарчим**

✓ Хийж гүйцэтгэсэн

**Гаалийг гололсон татвар хураамжийн хэлбэр （хуучин хэлбэр ）**

аж ахуйн нэгж бүртгүүлэх → гаалийн Тооцсон татвар → аж ахуйн нэгж Татвар тушаах → Гаалиар нэвтрүүлэх

**аж ахуйн нэгжийг гололсон татар хураамжийн хэлбэр （Шинэ хэлбэр ）**

аж ахуйн нэгж Нэгдсэн журмаар татвар мэдүүлэх →
- Бага эрсдэл Автоматаар татвар оногдуулах
- Өндөр эрсдэл Ажилтан хариуцсан хяналт

→ Гаалийн гол цэгийн хяналт

# 【Төсөл15】гаалийн АЕО-ийн харилцан баталгаажуулалтыг дэмжих нь

**Шинэчл элийн агуулга**

АЕО буюу “Баталгаажуулалтын чиглэлээр үйл ажиллаа явуулагч”. Одоогийн байдлаар, Хятадын гааль болон Сингапур, Солонгос, Хятадын Гонконг, Хятадын Тайван, Европын холбоо нь АЕО харилцан баталгаажуулалтын хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурсан. 7-р сарын 1-ны өдрөөс эхлэн Шанхайн чөлөөт худалдааны бүс нь гаалийн АЕО харилцан баталгаажуулалтыг дэмжих болсон. Харилцан баталгаажуулалт хийсний дараа улс бүр нь хоёр талын хэлэлцээрийн дагуу гадаад, дотоод худалдааг явуулахад тухайн улсын өндөр кредит зэрэглэлтэй аж ахуйн нэгж нь нөгөө улсад очиход хамгийн өндөр зэрэглэлтэй гаалиар нэвтрүүлэх таатай нөхцлийг эдлэх болно.

# Аж ахуйн нэгжийн удирдлагын шинэчлэл

***Төсөл16.аж ахуйн нэгжийн өөрийн удирдлагын журам***

✓ Хийж гүйцэтгэсэн

● аж ахуйн нэгжийг  өөрөө эсвэл зуулчлалын байгууллагаар өөрийн удирдлагыг явуулахад дэмжинэ.

● гааль  нь эрсдэлийн нөхцөл байдлыг үндэслэн  хэсэгчилсэн аж ахуйн нэгжид шалгалтыг хэрэгжүүлнэ.

● Аж ахуйн нэгж  нь үүссэн асуудлыг өөрөө шалгаж, засч залруулбал , гааль нь тохирсон хэмжээгээр холбогдох торгуулиас чөлөөлнө.

## 【Төсөл16】Аж ахуйн нэгжийн өөрийн удирдлага

**Шинэчлэлийн агуулга**

Гаалийн хяналтын хэлтэс нь аж ахуйн нэгжид дүрэм зөрчсөн үйлдэлд шалгалт хийнэ. Аж ахуйн нэгж нь хууль сахиулагч байгууллагад холбогдох үйлдлэлийн талаар тайлагнах бөгөөд энэ арга замаар гаалийн аж ахуйн нэгжид оногдуулах захиргааны торгууль.

# аж ахуйн нэгжийн удирдлагын шинэчлэл

***Төсөл17.аж ахуйн нэгжийн зохицуулагчийн журам***

*Хийж гүйцэтгэсэн*



“Цэгийг цэгт ” холбох системийг байгуулж, аж ахуйн нэгжийн бэрхшээлтэй байгаа асуудалд шуурхай хариу арга хэмжээ авах механизмийг бий болгох.

## 【Төсөл17】аж ахуйн нэгжийн зохицуулагч

**Шинэчлэлийн агуулга**

Зохицуулагчийн журам, эхлээд гаалийн ерөнхий газар нь Шанхайн гаальд 2013 оны сүүлээр туршилтын цэгийг ажлыг бүрэн эхлүүлж, АА ангилалын өндөр кредит зэрэглэлтэй аж ахуйн нэгжийн тусгай хөнгөлөлттэй үйлчилгээний арга хэмжээ рүү чиглэн ажилласан. Энэ удаагийн шинэчлэл нь "Шанхайн гаалийн чиглэлээр үйл ажиллагаа явуулагч аж ахуйн нэгжийн зохицуулагчийн платформ"-ыг байгуулж, мэргэжлийн хүнийг зохицуулагчийн албан тушаалд томилж, аж ахуйн нэгжид удирдлагын түвшинг дээшлүүлэхэд туслана.

# аж ахуйн нэгжийн удирдлагын шинэчлэл

***Төсөл18.аж ахуйн нэгжийн кредит мэдээллийг нээлттэй болгох***

✓ Хийж гүйцэтгэсэн

**中国（上海）自由贸易试验区海关**
**企业信用信息公开目录（2014 版）**

| 编号 | 信息类别 | 信息事项 | 公开属性 |
|---|---|---|---|
| 1 | | 企业名称 | 主动公开 |
| 2 | | 注册海关 | 主动公开 |
| 3 | | 海关经营类别（报关企业、收发货人等） | 主动公开 |
| 4 | | 报关有效期/年报期限 | 主动公开 |
| 5 | | 注销标志（正常、注销等） | 主动公开 |
| 6 | 海关注册登 | 企业类型 | 主动公开 |
| 7 | 记基本信息 | 法定代表人 | 主动公开 |

**Тогтсон хугацаанд 《/Шанхай/-н чөлөөт худалдааны туршилтын бүс гаалийн чиглэлэл үйл ажиллагаа явуулагч аж ахуйн нэгжийн кредитын мэдээ мэдээллийн жагсаалт》 боловсруулж, олон нийтэд ил тод болгох. Санаачлагаараа болон хүсэлтээр ил тод болгох гэсэн хоёр аргыг мэдээллийг олон нийтэд ил тод болгоно.**

# аж ахуйн нэгжийн удирдлагын шинэчлэл

***<u>Төсөл 19.Зуучлагч байгууллагыг гаалийн баталгаат хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд туслуулах.</u>***

✓ *хийж гүйцэтгэсэн*

- Зуучлагч байгууллагыг туршилтын бүсийн гаалийн баталгаат болон аж ахуйн нэгжийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд туслуулах.
- **Аж ахуйн нэгжийн болон гаалийн итгэмжлэл гэсэн хоёр хэлбэрийг ашиглах**
- Аудит, үнэлгээ, магадлагаа, баталгаажуулалт зэргийн туслах үндэслэлийг гаргаж өгөх.

Зуучлагч байгууллагыг гаалийн баталгаат болон аж ахуйн нэгжийн хяналт шалгалтын ажилд татан оролцуулж, зуучлалын байгууллалын гаалийн хяналт шалгалтанд оролцох салбар, ажлын хамрах хүрээг тэлэх.





# Тавдугаар ангилал：Үйл ажиллагааны хөгжил, шинэчлэл

**Төсөл20.Гадаад, дотоодын засварын журам** ✓ Хийж гүйцэтгэсэн

●Бүсэд өндөр хүчин чадалтай, дагалдах өртөг өндөртэй, бохирдолгүй гадаад, дотоодын засварын үйл ажиллагааг явуулна.

●Гааль нь гаалийн баталгаат үйлдвэрлэл, боловсруулалтын хяналт шалгалтын дагуу, мэдээ мэдээллийн системийг түшиглэн удирдлагыг хэрэгжүүлнэ.







# Үйл ажиллагааны хөгжил, шинэчлэл

## Төсөл21. Санхүүгийн түрээсийн журам

Хийж гүйцэтгэсэн

●Хэсэгчилэн тушаах түрээсийн төлбөрөөр гаалийн татвар болон НӨАТ-ыг хэсэгчилэн оногдуулна.

●Нөхцөл байдлыг хангасан аж ахуйн нэгжийг санхүүгийн түрээс, баталгаа үзүүлэхийг зөвшөөрнө.






# 【Төсөл21】Санхүүгийн түрээс

**Шинэчлэлийн агуулга**

**шинэчлэлийн өмнө**

- Зөвхөн Фу дун нисэх онгоцны нэгдсэн гаалийн баталгаат бүсэд туршилтын цэгийн үйл ажиллагааг явуулж байна.

**шинэчлэлийн дараа**

- Түрээслэгч аж ахуйн нэгж нь хэсэгчилэн түрээсийн төлбөрийг тушааж болно. Санхүүгийн түрээсээр авсан барааны тухайд гаалийн хяналт шалгалтаар тогтоосон түрээсийн мөнгөн дүнгийн дагуу хэсэгчилэн гаалийн татвар болон НӨАТ-ыг тушаахыг зөвшөөрнө.

# Үйл ажиллагааны хөгжил, шинэчлэл

**Төсөл22. Фьючерс баталгаат хүргэлтийн журам**

✓ Хийж гүйцэтгэсэн

- Гаалийн хяналттай барааг гол болгож фьючерс баталгаат хүргэлтийг явуулахыг зөвшөөрнө.
- Хүргэх бараа нь зэс, хөнгөн цагаан г.м

Шанхайн фьючерс дээр байгаа төрөл бүрийн бүтээгдэхүүн байна.








# Үйл ажиллагааны хөгжил, шинэчлэл

***Төсөл23.Гаалийн баталгаат үзэсгэлэн, худалдааны журам***

*Хийж гүйцэтгэсэн*

●Баталгаа гаргаж өгсөн нөхцөлд дотоод гадаададын заасан талбайд гаалийн баталгаат бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн ,худалдааг явуулж болно.

●Дотоодод бараанд эхлээд борлуулах, дараа нь татвар төлөх, нэгдсэн журмаар мэдүүлэх гэсэн зарчмыг хэрэгжүүлнэ.



# 【Төсөл23】Баталгаат гаалийн үзэсгэлэн худалдаа

Шинэчлэлийн агуулга

**шинэчлэлийн өмнө**

▪Зөвхөн аж ахуйн нэгжийг бүсэд баталгаат гаалийн үзэсгэлэнг явуулахыг зөвшөөрдөг.

**шинэчлэлийн дараа**

▪ аж ахуйн нэгжийг гаальд хангалттай хэмжээгээр татварын баталгаа （мөнгөний баталгаа, банкны баталгаа） -г гаргаж өгсөний дараа гадаад эсвэл дотоодын заасан талбайд гаалийн баталгаат бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн ,худалдааг явуулахыг зөвшөөрнө.

# （Шанхай）чөлөөт худалдааны Туршилтын бүсийг өргөтгөсний дараа худалдааг хөнгөвчилсөн шинэчлэлийн арга

——“Нэг шугамын нэвтрэлт、өндөр үр ашиг, удирдлага”-ыг бэхжүүлэх

——Олон улсын худалдааны “нэг цонх” бүтээн байгуулалтанд түлхэц үзүүлэх

——Нэгдсэн цогц судалгаа нь бараа бүтээгдэхүүний төлөв байдлын ангилал хяналт туршилтыг эрчимжүүлнэ

——Худалдааны өөрчлөлт, шинэчлэлд түлхэц үзүүлэх

——Олон улсад өрсөлдөх чадамжтай тээврийг хөгжүүлэх, журам болон үйл ажиллагааны хэлбэрийг сайжруулах.

## 1. “Нэг шугамын  нэвтрэлт, өндөр үр ашиг, удирдлага”-ыг бэхжүүлэх

•Боомтын хяналтын хэлтсүүдийн уялдаа холбоог сайжруулж, гаалийн бүрдүүлэлт хийх цаг хугацааны хязгаарыг дүрэмжүүлж, олон нийтэд зарлах. Аж ахуйн нэгжийг “Бие даан татвар мэдүүлэх, гаалийн бүрдүүлэлтэнд өөрөө туслах, автоматаар шалгах, гол цэгийг дахин хянаж шалгуулах” гэсэн хяналтын зарчмыг шинэчлэлд хамрагдахад дэмжих.





## 2.Олон улсын худалдаа “нэг цонх”бүтээн байгуулалтанд түлхэц үзүүлэх

●Олон улсын худалдааны “нэг цонх”-ын барааны импорт, экспорт болон тээврийн хэрэгслийг хилээр оруулах, гаргахад ашиглах программыг боловсронгуй болгож, боомтын хяналт, хууль сахиулах, гааль бүрдүүлэлтийн үйл явцыг улам сайжруулж, худалдааны зөвшөөрөл, төлбөр тооцоо , зөвшөөрлийн бүртгэл зэрэг платформын функцуудыг хэрэгжүүлж, худалдааны хяналтын хэлтэсийг аажмаар “нэг цонх” –ны удирдлагын платформ руу оруулна. **Чансанжиао бүсийн олон улсын худалдаа “нэг цонх”-ийг байгуулж**, Чанжянь эдийн засгийн бүсийн гаалийн бүрдүүлэлтийн интеграцчлалд түлхэц үзүүлнэ.

# Олон улсын худалдаа “нэг цонх” -ийн бүтээн байгуулалтын ерөнхий мэдээлэл

## （1）Олон улс

**《НҮБ-ын худалдааг хөнгөвчилөх 33、34、35-т санал зөвлөмж 》**

- **Олон улсын худалдааны нэг цонхыг байгуулах**
- **Олон улсын худалдааны өгөгдлийг хялбаршуулж, Стандартчилах**
- **Олон улсын худалдааны нэг цонхны хууль эрх зүйн орчинг байгуулах**

**ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр （ Балийн хэлэлцээр ）**

- **Гишүүн улс нь бүхий л хүчин чадлаараа** Худалдаачдыг нэвтрүүлэх бүрэн боломжтой портыг байгуулж, холбогдох засгийн газрын байгууллагад барааны импорт, экспорт дамжуулалтанд шаардагдах баримт цахим өгөгдлийг өргөн барих. Баримт, мэдээ мэдээллийг холбогдох засгийн газрын байгууллагаар шалгуулсаны дараа үр дүнг нь нэг цонхоор дамжуулан цаг тухайд нь өргөдөл гаргагч этгээдэд мэдэгдэх.
- **Баримт эсвэл цахим өгөгдлийг нэг цонхоор дамжуулан хүлээн авсан тохиолдолд холбогдох засгийн газрын байгууллага нь ижил баримт эсвэл өгөгдлийг өргөн барих шаардахгүй. Онцгой нөхцөл байдал эсвэл бусад ил тод болгохыг хориглосон нөхцөл байдлаас бусад тохиолдолд**

# Олон улсын худалдаа төвийн “нэг цонх” -ийн ерөнхий мэдээлэл

## （2）Дотоод

**《 Коммунист намын Төв хорооны гарсан шийдвэр 》**

Мэдээ мэдээлэл солилцох, хяналтыг харилцан баталгаажуулах, хууль хэрэгжүүлэхэд харилцан туслах

**“Арван хоёр дахь таван жил” -ийн төлөвлөгөөнд тусгагдсан цахим боомтын хөгжил**

Хөгжлийн зорилт : 2015он гэхэд цахим боомтын платформын дэд бүтцийг нэг шат сайжруулж, цахим боомтын платформын гаалийн бүрдүүлэлт, ложистик, худалдааны үйл ажиллагааг нэг шат ахиулж, аж ахуйн нэгжийн гааль бүрдүүлэлтийг улам үр ашигтай, дэс дараалалтай, хурдан шуурхай болгоно. Боомтын нэгдсэн хууль сахиулах болон үйлчилгээний чадамжийг улам нэмэгдүүлж , олон улсын “Нэг цонх” бүтээн байгуулалтын журам болон ерөнхий стандартад нийцүүлж, эдийн засаг , нийгмийн хөгжлийн шаардлагад нийцсэн Хятадын онцлогийг харуулсан “нэг цонх” ажлыг эхний ээлжинд хийж гүйцэтгэнэ.

**Төрийн зөвлөлөөс гаргасан “Гадаад худалдааны өсөлтийг дэмжих тухай санал зөвлөмж”**

Цахим боомтын бүтээн байгуулалтыг хурдасгаж,олон улсын худалдааны “нэг цонх”-г хэрэгжүүлж， …… боомтын хэлтэс болон орон нутгийн засаг захиргааны мэдээ мэдээллийг солилцох

# Шанхайн худалдааны туршилтын чөлөөт бүсийн
# Олон улсын худалдаа нэг цонхны бүтээн байгуулалт

## Бүтээн байгуулалт（2014оны 2-р сарын 21-ны өдөр）

Шанхай хотын зөвлөл, тамгын газар үүийг онцлон үзэж, бүхий л төрлийн дэмжлэг үзүүлсэн.

Улсын боомтын газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Дотоодыг хамгаалах яам, Зам тээврийн яам

- Шанхайн гааль , Шанхай улсын шалгалт, хорио цээрийн газар, Шанхайн гаалийн хэрэг эрхлэх газар, Шанхайн хилийн шалганы ерөнхий газар
- Хотын хөгжил, шинэтгэлийн хороо, хотын эдийн засаг, мэдээлэл технологийн зөвлөл, хотын бизнесийн зөвлөл, хотын зам тээврийн зөвлөл
- Хотын боомтын үйлчилгээний оффис, Шанхайн цахим боомтын оффис, нисэх онгоцны буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулагч групп, боомтын чиглэлээр үйл ажиллагаа явуулагч групп

Үүний зэрэгцээ Худалдааны яам, Татварын ерөнхий газар, хүнс, эмийн хяналт шалгалтын ерөнхий газар, удирдлагын оффис зэрэг яам, зөвлөлийн тусламж, удирдамжийг авсан.



# Шанхайн худалдааны туршилтын чөлөөт бүсийн
# Олон улсын нэг цонхны худалдааны бүтээн байгуулалт

## Олон улсын нэг цонхны худалдааны веб сайт （2015.6.30）




Шинээр 23-н төслийг нэмнэ. Зургаан чиг үүргийн модулиудыг цогцоор хамрах бөгөөд
Гааль, улсын шалгалт, хорио цээрийн газар, гаалийн хэрэг эрхлэх газар, хилийн шалган, иргэний нисэх, шуудан, өөрчлөлт, шинэчлэл, эдийн засаг, мэдээлэл технологи, худалдаа, зам тээвэр, улсын татвар, гадаад валют, санхүү, хүнс, эмийн хяналт шалгалт, удирдлага, нисэх онгоцны буудал, боомт зэрэг 17-н байгууллагыг хамруулна.

**Хотын хөгжил, шинэтгэлийн хороо, хотын эдийн засаг, мэдээлэл технологийн зөвлөл, хотын бизнесийн зөвлөл, хотын зам тээврийн зөвлөл, хотын татварын ерөнхий газар, хотын санхүүгийн оффис, нисэх онгоцны буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулагч групп, боомтын чиглэлээр үйл ажиллагаа явуулагч групп, шуудангийн газар, Зүүн Хятадын иргэний нисэхийн асуудал эрхэлсэн газар, Шанхайн гадаад валютын арилжааны салбар, улсын удирдлагын оффисын Шанхай хот дахь оффис**

# Шанхайн Олон улсын нэг цонхны худалдааны бүтээн байгуулалтын ерөнхий мэдээлэл

## Олон улсын нэг цонхны худалдааны веб сайт （2016.1）




Функц нь , ашиглахад улам хялбар болж, механизмд ямар саадгүй болсон. 16-н зүйлийг нэмж, Мобайл интернэт хувилбарыг танилцуулсан.

## 3. Нэгдсэн цогц судалгаа нь бараа бүтээгдэхүүний төлөв байдлын ангилалд хяналт туршилтыг эрчимжүүлнэ

- Бараа бүтээгдэхүүний ангилал төрөлжүүлэлтийн удирдлагын туршилтаар дамжуулж, туршилтанд хамрагдсан аж ахуйн нэгж нь ялган төрөлжүүлэх, савлах, үйлчлүүлэгчид хүлээлгэн өгөх зэргийг нэгтгэн цогц байдлаар хэрэгжүүлнэ. Нийлүүлэх хугацаа 72 цаг байсныг 24 цаг болгон багасгаснаар сар бүр тээврийн өртгөөс 20 000 юанийг хэмнэх боломжтой. Тус модуль нь аж ахуйн нэгжийн цэвэр ложистикийн чиглэлийн ангилал болон худалдааны тооцооны төвийн хөгжил юм.

# Хоёр:Шанхайн худалдааны туршилтын чөлөөт бүсийн худалдааг хөнгөвчилсөн хяналтын шинэчлэлээс ирэх ашиг

**“Эхлээд бүс рүү оруулах, дараа нь гаальд мэдүүлэх” Хилээр оруулах барааг боомтын агуулах хүртэл дунджаар 2-3 өдрөөр богиносгож ложистикийн үндсэн өртөгийг дунджаар 10% бууруулна.**

**“Бүсэд өөрөө тээвэрлэх” аж ахуйн нэгж нь тээвэрлэлт бүрээс ойролцоогоор 30 минутыг хэмнэж, жил бүр ложистикийн өртөгөөс 200000 юаниас илүүг хэмнэх болно. ;**

**“Автомат картаар хянаж шалгуулах” Бараанд карт ашигласнаар 6 минутаас 5 секунд хүртэл хугацааг богиносгоно.**

## Шанхайн худалдааны туршилтын чөлөөт бүсийн худалдааг хөнгөвчилсөн хяналтын шинэчлэлээс ирэх ашиг

- **2.аж ахуйн нэгжид ирэх ашиг улам нэмэгдэнэ. Улс хоорондын худалдааг хөнгөвчилсөн хамтын ажиллагааг хөгжүүлэх**
- "аж ахуйн нэгжийн бүртгэлийн шинэчлэл: " " Нэг газарт бүртгүүлж, бүхий л улс даяар мэдүүлэг хийх " зарчмыг хэрэгжүүлнэ;
- Аж ахуйн нэгжийн " нэг цэгийн"үйлчилгээ: Гаальд мэдүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж нь гэрчилгээг сольж бүртгүүлэхэд нь зөвхөн ажлын 3-н өдөр шаардлагатай.
- Гаалийн АЕО харилцан баталгаажуулалтын зарчим: Бүсийн 120-н АА ангилалын аж ахуйн нэгж нь дотоод болон бараа экспортлох улс /бүс нутаг/ -ын гаальд өндөр зэрэглэлээр бүрдүүлэлт хийх таатай нөхцлийг зэрэг эдлэх болно.

# Шанхайн худалдааны туршилтын чөлөөт бүсийн худалдааг хөнгөвчилсөн хяналтын шинэчлэлээс ирэх ашиг

## 3. Зах зээлийн субьектийн чадамжийг илт нэмэгдүүлсэн.

- **Аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалтын тал дээр: Гадаадын хөрөнгө оруулалтын тал дээр**, 2015 онд шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн тоо нь 2014 оноос 1.5 дахин нэмсэнтэй тэнцэж байна. Хотын бараг тэн хагас болох гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь чөлөөт худалдааны бүсэд байрлаж байна. Шинээр бүртгүүлсэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо нь чөлөөт худалдааны бүсийн анх нээсэн байх үеийн 5%-иас 2015 онд болоход 20% болж нэмэгдсэн. Шинээр бүртгүүлсэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дундаж дүрмийн сан нь /ойролцоогоор 15000000 ам доллар/ дотоодын аж ахуйн нэгжийн дундаж дүрмийн сан /ойролцоогоор 50000000 юань/ -г хоёр дахин нэмсэн хэмжээтэй тэнцүү байна. **Хилийн чанд дахь хөрөнгө оруулалтын тал дээр**: 2015 онд Шанхай чөлөөт худалдааны туршилтын бүсийн хамтран тооцсон хилийн чанд дахь хөрөнгө оруулалтын төсөл нь 636-н ширхэг, 2014 оны 149-н ширхэг төслийг 4.3 дахин нэмсэн хэмжээтэй тэнцүү байна. Хятад талын хөрөнгө оруулалт 22.9 тэрбум ам доллар /хотын 60%-ийг эзэлнэ/ , 2014 оны 4.2 тэрбум долларыг 5.5 дахин нэмсэнтэй тэнцүү байна. Хилийн чанд дахь бодит хөрөнгө оруулалт нь（7.9 тэрбум ам доллар）ойролцоогоор улсын （118 тэрбум ам доллар ）7%-ийг эзлэж байна.
-

## Шанхайн худалдааны туршилтын чөлөөт бүсийн худалдааны хяналтын шинэчлэлээс ирэх ашиг

### 4.Бүсийн импорт, экспорт илт нэмэгдэх

2015онд чөлөөт худалдааны бүсийн гаалийн баталгаат бүс нь 741,55 тэрбум юань буюу Шанхай хотын 26.4%-ийг эзлэх хэмжээний импорт, экспортыг хийж гүйцэтгэсэн. Тээвэрлэлтийн тал дээр 2015онд Яаншань боомт болон Вайгаочиао боомтын бүс нь нийт 33.572.000 ширхэг чингэлэг нэвтрүүлж, 3.7%-иар нэмэгдүүлж, Шанхай боомтын дэлхийн тэргүүлэгч гэдэг байр суурийг хадгалахад дэмжлэг үзүүлж байна.





# Шанхайн худалдааны туршилтын чөлөөт бүсийн худалдааны хяналтын шинэчлэлээс авчирах ашиг

**5.Бүсийн гол үйл ажиллагааг тасралтгүй өргөжүүлэн тэлэх**

**Баталгаат гаалийн үзэсгэлэн, худалдаа “эхлээд дэлгүүр, дараа нь агуулах” хэлбэр，Бараа боруулахад 20 -30 % хөнгөлөх; Санхүүгийн түрээс 220-н гаальд бүртгэлтэй аж ахуйн нэгж， 13 ш санхүүгийн түрээсийн нисэх онгоц , гадаад дотоодын засварын 9-н ширхэг аж ахуйн нэгж үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд олон арван аж ахуйн нэгж нь саналаа илэрхийлсээр байна.**







# Гурав.Хятад（Шанхай） худалдааны чөлөөт туршилтын бүсийн худалдааг хөнгөвчилж хөгжүүлэх чиг хандлага

- **Олон улсын худалдааны “нэг цонх” бүтээн байгуулалтыг сайжруулж, эдийн засгийн бүсийн гаалийн мэдүүлгийн интеграцчлалд түлхэц үзүүлэх**
- **Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтанд шинэ журамаар шалгалт хийх**
- **Улс хооронд худалдааг хөнгөвчлөх хамтын ажиллагааг явуулах**
- **Аажмаар үйлчилгээ, худалдааг хөнгөвчилөх арга хэмжээнд түлхэц үзүүлэх,**





## 1.Чанжянь эдийн засгийн бүсэд байгуулсан “нэг цонх”

- 2015оны 12-р сарын 29-ны өдөр，Чан Санжиао Бүсийн гаалийн бүртгүүлэлтийн бүтээн байгуулалтын гэрээний 8 дахь удаагийн хамтарсан хурлыг Шанхайд зохион байгуулсан. Жансу, Жөжянь, Анхуй, Шанхай гэсэн 4-н муж, хот нь Чан Санжиао бүсийн олон улсын худалдааны “Нэг цонх”-ны бүтээн байгуулалтыг эхлэхээр олон нийтэд зарласан. Одоогийн байдлаар Чан Санжиао бүс нь интеграцчлалын хэлбэрээр мэдүүлсэн мэдүүлгийн хэмжээ Чанжянийн эдийн засгийн бүсийн 90%-ийг ойролцоогоор эзлэж байгаа бөгөөд улсын гаалийн мэдүүлгийн нийт тоо хэмжээний тэн хагастай ойролцоо байна.

## 2.Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын шинэ дүрэм журмыг турших

- 2015 оны 9 сард Хятад улс нь Дэлхийн худалдааны байгууллагын WTO “Худалдааны хөнгөлөлтийн хэлэлцээр”-д нэгдсэн нь манай улсын худалдааны хөнгөлөлтийн хяналт удирдлагын тогтолцоог ахиулан урагшлуулахад ашиг тустай төдийгүй Шанхай тэргүүтэй чөлөөт худалдааны бүсийн олон улсын худалдаа болон агаарын тээврийн төвийн статусыг бэхжүүлж, транзит худалдаа болон далай эргийн бизнес үйл ажиллагааг хөгжүүлэхэд ач тустай юм.
- 2015 оны 10 сарын 5 өдөр анхан шатны тохиролцоонд хүрсэн TPP гэрээний 5-р бүлэгт гаалийн удирдлага болон худалдааны хөнгөлөлтийн талаар: Гаалийн холбогдолтой хууль тогтоомж, ачаа барааг шалгах, тогтмол бус хугацаанд төлөх татвар хураамж зэрэг үйл явцын ил тод байдал болон гаалийн удирдлагын цогц шинж чанар зэргийг голчлон тусгасан.
- Гаалийн болон хилийн үйл ажиллагааны үйл явцыг хөнгөвчлөх замаар, экспресс тээврийн үйлчилгээнд яаралтай үйлчилгээг нэмж, жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн бизнес болон бүс нутагийн нийлүүлэлтийн гинжин холбооны хөгжлийг эрчимжүүлнэ.

## 3. Улс хоорондын худалдааг хөнгөвчилсөн хамтын ажиллагааг хөгжүүлэх

- “Нэг бүс нэг зам” стратегийн санаачлагыг хэрэгжүүлэх явцтай холбохын тулд Шанхай чөлөөт худалдааны туршилтын бүс нь хилийн дагуух гааль хоорондын олон улсын хамтын ажиллагааг бэхжлүүлэх. Шахайн олон улсын агаарын тээврийн төвийн байр суурийг ашиглаж дэлхийн агаарын тээврийн нөөц бололцоо, чадамжийг тасралтгүй нэмэгдүүлж, бүсийн дагуух замын гол огтлолын цэгийн хотын гаалийн үйл ажиллагааны хамтын харилцаа холбоог бэхжүүлэх. Боомтын бүсүүдийн уялдаа холбооны механизмыг сайжруулж, олон улсын төв боомтын уялдаа холбоотой хөгжлийг дэмжиж, “Нэг бүс нэг зам” замын дагуух төв хотын үйл ажиллагаанд чухал үүргийг гүйцэтгэх.

# 4. Үйлчилгээ, худалдааг хөнгөвчилсөн арга хэмжээнд алхам алхамаар түлхэц үзүүлэх

- Хэдийгээр чөлөөт худалдааны туршилтын бүсийн ерөнхий төлөвлөгөөнд санхүү, тээвэр, худалдаа, мэргэжил, соёл болон нийгэм зэрэг үйлчилгээний салбарт өртгөтгөл хийж, нээлттэй болгох санал гаргаж, хөрөнгө оруулагчийн хөрөнгийн чанарын шаардлага, хувьцааны хязгаарлалт, бизнес эрхлэх цар хүрээний хязгаарлалт зэргийг түр болон бүр мөсөн арилгасан. Боловч үйлчилгээ, худалдааг хөнгөвчилөхөд дэмжлэг үзүүлэх тал дээр одоогийн байдлаар гаргасан хууль тогтоомж, арга хэмжээ харьцангуй бага байгаа учраас үйлчилгээ, худалдаа болон боомтын худалдааг хөнгөвчилөх явцад бүхий л хүчин чадлаараа дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.
- Үйлчилгээ худалдаа нь барааны худалдаатай агуулга болон хэлбэрийн тал дээр харьцуулахад маш их зөрүүтэй, энэ хоёрыг хөнгөвчилөхөд үүсэх асуудал нь өөр өөр , тухайлбал татвар хураамжийн хөнгөлөлт, санхүүгийн татаас, гадаад валютын арилжааны хяналт, нэвтрэх зөвшөөрөл, хувьцааны харьцаа, үйл ажиллагааны чиглэл, бизнесийн ажилчдын хөдөлгөөн зэрэг тал дээр зөрүүтэй байна. Манай улсын чөлөөт худалдааны туршилтын бүс нь байрлаж буй хотоо бүсийн санхүү, тээвэр, худалдааны төвийн гол байр суурь болгон бүрэн ашиглаж хил дамнасан цахим худалдаа, бизнесийн факторинг, санхүүгийн түрээс зэрэг үйлчилгээ худалдааны шинэ загвараар хөнгөвчилж хөгжүүлэх арга хэмжээг эрэн хайж, худалдаа, санхүү, олон улсын төлбөр тооцоо, гадаад валют арилжааны хяналтын шинэ хэлбэрийг бий болгоно.

上海对外经贸大学
SHANGHAI UNIVERSITY OF INTERNATIONAL BUSINESS AND ECONOMICS

# баярлалаа !



Гао Юун Шенг
E-Mail：dinogys@126.com